



**“ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ, АРГАЛАНТ, БАЯНЧАНДМАНЬ,
БАЯНДЭЛГЭР, БАЯН, ЭРДЭНЭ, СЭРГЭЛЭН СУМДЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль, эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.” гэж заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.” гэж, Газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Хилийн цэс, газар усны нэрийг Улсын Их Хурал, газрын сангийн зургийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.” гэж, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад Улсын Их Хурал 1:25000-аас багагүй масштабтай байр зүйн зурагт тэмдэглэгдсэн аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийн зургийг батлахаар тус тус заасан.

Түүнчлэн “Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 2 дахь заалтад нийслэлийн хилийн цэсийг баталсантай холбогдуулан Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

1.2.Практик шаардлага

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн “Хилийн цэс батлах тухай” 1982 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн 131 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралтаар “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хилийн цэс”-ийг, 2 дугаар хавсралтаар “Төв аймгийн Батсүмбэр, Архуст, Эрдэнэ, Баянжаргалан сумдын нутаг дэвсгэрийн хилийн цэс”-ийг тус тус шинэчлэн баталсан.

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 2 дахь заалтад нийслэлийн хилийн цэсийг баталсантай холбогдуулан Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн

цэсийг шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Мөн дээрх тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсоноор Төв аймгийн Батсүмбэр, Архуст, Эрдэнэ, Баянжаргалан сумдын хилийн цэс хүчингүй болсон бөгөөд Улсын Их Хурлын 1998 оны 42 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 3 дахь заалтын "131 дүгээр зарлигийг" гэснийг "131 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралтыг" гэж өөрчилснөөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралт эргэж хүчин төгөлдөр болсон байна.

Дээр дурдсан шийдвэрүүдийн дагуу Төв аймгийн Батсүмбэр, Архуст, Эрдэнэ, Баянжаргалан сумдын нутаг дэвсгэрийн хилийн цэс хүчин төгөлдөр хэвээр үлдсэнээр Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолоор баталсан нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэстэй давхцал үүсгэж, дор дурдсан асуудлууд үүссэн байна. Үүнд:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигаар баталсан Төв аймгийн Эрдэнэ сумын хилийн цэс, Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн хилийн цэс хооронд давхцал үүссэн.

Мөн газар нутгийн давхцалын улмаас Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 21 иргэн, хуулийн этгээдийн 151.6 га, Аргалант сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 3 иргэн, хуулийн этгээдийн 8.9 га, Баянчандмань сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 211 иргэн, хуулийн этгээдийн 102.1 га, Эрдэнэ сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 1622 иргэн, хуулийн этгээдийн 3441.45 га, Сэргэлэн сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 212 иргэн, хуулийн этгээдийн 175.5 га газар буюу нийт 2069 иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх хөндөгдөж байна.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 169 дүгээр тогтоолын 1-д "Нийслэлийн Налайх дүүрэг Төв аймгийн Эрдэнэ, Сэргэлэн сумдтай, Хан-Уул дүүрэг тус аймгийн Аргалант, Алтанбулаг сумдтай, Сонгинохайрхан дүүрэг тус аймгийн Баянчандмань, Баянцогт сумдтай хиллэж байгаа хэсгүүдэд үүссэн хилийн цэсийн маргааныг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэс"-ийн дагуу шийдвэрлэх саналыг дэмжсүгэй" гэж, Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар тогтоолоор Эрдэнэ сум, 04 дүгээр тогтоолоор Сэргэлэн сум, 05 дугаар тогтоолоор Баянчандмань сум, 06 дугаар тогтоолоор Алтанбулаг сум, 07 дугаар тогтоолоор Аргалант сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дэмжиж Монгол Улсын Засгийн газарт уламжлахаар тус тус шийдвэрлэсэн болно.

Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагуудын саналыг нэгтгэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах шаардлага үүссэн.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 2 заалттай байх бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

1 дэх заалтаар Нийслэлтэй хил залгаа Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баян, Баяндэлгэр, Баянчандмань, Сэргэлэн, Эрдэнэ сумдын хилийн цэсийг хавсралт ёсоор шинэчлэн батлахаар;

2 дахь заалтаар тус тогтоол гарсантай холбогдуулан “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 73 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтын “13.Алтанбулаг”, “14.Аргалант” гэсэн хэсэг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1980 оны 84 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралтын “4.Баян”, “5.Сэргэлэн” гэсэн хэсэг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 280 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын “Баяндэлгэр” гэсэн хэсэг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийн хоёрдугаар хавсралтын “4.Эрдэнэ” гэсэн хэсэг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1983 оны 106 дугаар зарлигийн “5.Баянчандмань” гэснийг тус тус хүчингүй болсонд тооцохоор тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Нийслэл хот болон Төв аймгийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийн маргаан, газрын давхцал арилж, иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нэг мөр зохион байгуулах боломж бүрдэнэ.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 28/14 дугаар тогтоолоор Налайх дүүргийг Нийслэлийн дагуул хот болгох “дагуул хотын ерөнхий төлөвлөгөө” нь нийт газар нутгийн хэмжээнд хэрэгжих нөхцөл бүрдэнэ.Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн нийт 69126 мян.га газрын эрх баталгаажиж, стратегийн томоохон бүтээн байгуулалтууд хийгдэх нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль тогтоомж, газар зохион байгуулалтын журмын дагуу хилийн цэсэд өөрчлөлт оруулах үйл ажиллагаа хийгдэнэ. Нийслэл хоттой хил залгаа Төв аймгийн сумдын хилийн цэсийг баталсан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нийт 4 зарлигийн зохицуулалт нэгдсэн зохицуулалттай болно.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын шийдвэрээр хилийн цэсийн давхцалтай хэсэгт олгогдсон 21 иргэн, хуулийн этгээдийн 151.6 га, Аргалант сумын Засаг даргын шийдвэрээр 3 иргэн, хуулийн этгээдийн 8.9 га, Баянчандмань сумын Засаг даргын шийдвэрээр олгогдсон 211 иргэн, хуулийн этгээдийн 102.1 га, Эрдэнэ сумын Засаг даргын шийдвэрээр олгогдсон 1622 иргэн, хуулийн этгээдийн 3441.45 га, Сэргэлэн сумын Засаг даргын шийдвэрээр олгогдсон 212 иргэн, хуулийн этгээдийн 175.5 га газрын эрхийн баталгаажуулалтыг шинэчлэн зохион байгуулна.

Төв аймгийн холбогдох сумдын удирдлага, ард иргэд, малчдад хилийн цэсийн өөрчлөлтийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, Алтанбулаг, Аргалант, Баянчандмань, Эрдэнэ, Сэргэлэн сумын Засаг даргын захирамжаар

олгогдсон нэгж талбарыг харьяалах нэгжээс холбогдох гэрээ, гэрчилгээг олгох, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тогтоолын төслийн талаар

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хуультай нийцүүлэн боловсруулна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй бөгөөд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 73 дугаар зарлиг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1980 оны 84 дүгээр зарлиг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 280 дугаар зарлиг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлиг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1983 оны 106 дугаар зарлигийн холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах асуудлыг тогтоолын төслийн 2 дахь заалтаар зохицуулахаар тусгана.

---o0o---